



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 4 дүгээр сарын 3-ны  
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 126

### ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:**

1. “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4.1 дэх хэсгийн “...хамгаалахад зайлшгүй шаардлагатай ажил гүйцэтгүүлэх” гэсний дараа “, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах;” гэж нэмсүгэй.

2. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтанд олгох нэмэгдэл хөлсийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд жил бүрийн батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Боловсрол, соёл, шинжлэх  
ухаан, спортын сайд

Ё.БААТАРБИЛЭГ